

2025.09

VIP 76+

126
ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ
ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ



БАРУУН БҮС
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ЧӨЛӨӨТ БҮС
БОЛОН ХӨГЖИНӨ

Загджав

МЭНДСАЙХАН

Монгол Улсын Их Хурлын гишүүн



Монгол Улсын Их Хурал



Загджав МЭНДСАЙХАН

- Монгол Улсын Их Хурлын гишүүн
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн
- Төсвийн байнгын хорооны гишүүн

mendsaikhan@parliament.mn

Загджавын Мэндсайхан

51-267006

АЖЛЫН ХЭСЭГ

- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн ажлын хэсэг
- Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Хүнс, эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Үндэсний аудитын газрын “Оюу толгой төсөлд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүжилтийн зарцуулалт, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэж байгаатай холбогдуулан, санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Холбоо, сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Ашигт малтмалын тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- Эрчим хүчний салбарын шинэтгэлийн хүрээнд Эрчим хүчний тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг
- “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 31 дүгээр тогтоолын хэрэгжилттэй танилцаж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг

ПАРЛАМЕНТЫН БҮЛЭГ

- Монгол-Норвегийн парламентын бүлгийн дэд дарга
- Монгол-Саудын Арабын парламентын бүлгийн дэд дарга
- Монгол-Сингапурын парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Урагвайн парламентын бүлгийн гишүүн
- Монгол-Швейцарын парламентын бүлгийн гишүүн

2024 ОНЫ НАМАР, 2025 ОНЫ ХАВРЫН ЧУУЛГАНЫ ИРЦ



3. Мэндсайхан

УИХ-ын гишүүн

БАНУУН БУС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧӨЛӨӨТ БУС БОЛОН ХӨГЖИНӨ

МЭНДСАЙХАН



8 ЧИГ ҮҮРГИЙН ДАВХАРДАЛТАЙ 29 ЗӨВЛӨЛ, ХОРООДЫГ ТАТАН БУУЛГАЖ, ТӨСВӨӨС 41.6 ТЭРБУМЫГ ХЭМНЭЛЭЭ

10 “ЦАГААН АЛТ” ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАРЫГ ХАНГАХАД АНХААРНА

12 “ХАЛЗАН БҮРЭГТЭЙ”-Н СОНСГОЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИРГЭДИЙН МЭДЭХ ЭРХИЙГ ХАНГАНА

14 НД-ЫН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТӨӨР ИРГЭДИЙН ОРЛОГО НЭМЭГДЭЖ ААН-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БАТАЖНА

15 АЛСЛАГДСАН БҮСИЙН ИРГЭД ХХОАТ-Т 10 БИШ 1 ХУВИЙН ТАТВАР ТӨЛДӨГ БОЛНО

16 ЖАРАН ЖИЛ ДУНШСАН ЭРДЭНЭБҮРЭНГИЙН УЦС-ЫН ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ ШИЙДЭГДЛЭЭ

18 БАНУУН БҮСИЙГ ШААРДЛАГА ХАНГАСАН УНДНЫ УСААР ХАНГАХ АЖИЛ БОДЛОГЫН ТҮВШИНД ЯАРАЛТАЙ ХИЙГДЭХ ЁСТОЙ

19 МОНГОЛЫН ХӨНГӨН ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧДИЙГ ШИНЭ ХОВД ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК РУУ ТАТЪЯ

20 ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БҮЮУ УТААНЫ СОНСГОЛ

22 126 ГИШҮҮНТЭЙ ПАРЛАМЕНТЫН АНХНЫ ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО ОЮУТОЛГОЙН АСУУДЛААР БАЙГУУЛАГДЛАА

23 БИЗНЕС ЭРХЛЭГЧ ХООРОНДЫН ШҮҮХИЙН МАРГААНЫГ ЗАРДАЛ БАГА, ТҮРГЭН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

24 УЛСЫН АВАРГУУД ТОДОРЛОО

25 МАЛЧИН ӨРХИЙН 1 ХҮҮХЭД ҮНЭГҮЙ МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИНЭ

26 ӨРХИЙН БОДИТ ОРЛОГО 15% ӨСӨХӨӨР ТӨР БОДЛОГОО ТОДОРХОЙЛОВ

126 ГИШҮҮНТЭЙ АНХНЫ ПАРЛАМЕНТЫН 1 ЖИЛ

35 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН “ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ” БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛЫН ХЭСГҮҮД АЖИЛЛАЖ БАЙНА

36 ХҮН ТӨВТЭЙ, ИРГЭНИЙ ОРЛОЦООТОЙ ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ

37 УРАНЫ ТӨСӨЛ МОНГОЛД УЛСАД “ХАРААТ БУС” БАЙХ БОЛОМЖИЙГ НЭЭВ

38 ИМПОРТЫН ГУРИЛЫН ТАТВАРЫГ ТЭГЛЭСНИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ

39 ЕРӨНХИЙЛӨГЧИЙН “ХОРИГ”-ИЙН ХҮРЭЭНД ТӨСВӨӨ ДАХИН ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛЛАА

40 ЗЭЭЛДЭГЧИЙН “ХАР ЖАГСААЛТ” ГЭХ САНХҮҮГИЙН ЯЛ ХАЛАГДЛАА

41 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСНААР ХҮН ТӨВТЭЙ ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН СУУРЬ ТАВИГДАНА

42 ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ХҮМҮҮСИЙН ТОО 65 ХУВИАР БУУРНА

43 21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ “ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ УРАГШИЛЛАА



30 ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

32 БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО




БАРУУН БҮС ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧӨЛӨӨТ БҮС БОЛОН ХӨГЖИНӨ

Миний бие нийслэл хотоос 1000-1500 км-ийн зайд оршдог, байнгын ажиллагаатай боомттойгоороо онцлог Увс, Ховд, Говь-Алтай, Завхан аймаг буюу Баруун бүсийн ард иргэдээ төрд төлөөлөн ажиллаж буй гишүүн. Монгол Улс хөгжлийн дараагийн гарцыг БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ хэмээн тодорхойлж 2024 оноос бодлого, хөтөлбөрөө батлан хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Баруун аймгуудад Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр суурилсан хөгжлийг явуулахад гол тулгамдаж буй асуудал нь тээвэр ложистик. Учир нь ард иргэдийн 80-90 хувь нь төв суурин газраас хүнс, бараа бүтээгдэхүүнээ татаж авахын тулд 1-2 дахин нэмэгдсэн үнэ төлөх болдог. Энэ нь амьдралын чанарт шууд нөлөөлж байна.

Тиймээс бүс нутгийн боомтууд дээр суурилсан гадаад худалдааны эдийн засгийг бий болгох чиглэлд бодлого төвлөрүүлэх шаардлагатай болсон юм. Хамгийн зөв зохистой тээвэр ложистикийг, хамгийн зөв байрлал дээр тооцоолон гаргаж хувийн хэвшлүүдээ дэмжиж, бүс нутгийнхаа ард иргэдийн амьдралын чанарт анхаарахыг чухалчилж байна.





28000 га

талбайд баригдах Эрдэнэбүрэнгийн

90 мегаваттын усан цахилгаан станц нь баруун бүс болон Алтай-Улиастай орчмыг ногоон эрчим хүчээр **100** хувь хангана.

Төслийн хэрэгжих хугацаа 61 сар буюу **5 жил 1 сар**.

Нөгөө талдаа баруун аймгуудыг эрчим хүчний хараат байдлаас гаргах Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц ашиглалтад орохоор хөнгөн үйлдвэрлэл хөгжих боломж нээгдэнэ. Үүнийг түшиглэж Ховд аймагт Үйлдвэр технологийн паркийг төлөвлөн бүтээн байгуулалтын ажлууд үргэлжилж байна. Үүнийг **үйлдвэрлэлийн чөлөөт бүс** гэж нэрлэж болно.

Учир нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлаар үйлдвэрлэл явуулахад шаардлагатай дэд бүтэц буюу ус, цахилгаан, дулаан, цэвэрлэх байгууламжийг 200 га газарт төлөвлөж, бүтээн байгуулалтын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Ингэснээр хувийн хэвшлүүд малын гаралтай түүхий эд, хүнсний үйлдвэрүүдээ байгуулахад дэд бүтцийн зардал гаргах шаардлагагүй болох юм.



 Төслийн талбай

Ховд хотоос **85** км, Эрдэнэбүрэн сумын төвөөс **25** км, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумаас **54** км зайд орших Ховд гол дээрх Шижигтийн хавцалд буюу 3 аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан уулзвар дээр босож буй бүтээн байгуулалт юм.



Нөгөөтэйгүүр тэд үйлдвэр байгуулах, салбараа нээх, үйл ажиллагаагаа өргөтгөхөд хөнгөлөлттэй зээлийн асуудал маш чухал. Энэ хүрээнд миний бие “Цагаан алт” хөтөлбөрийг санаачлан боловсруулж, 2024 оны зургаадугаар сард УИХ-аар батлуулж, улсын төсөвт 77 тэрбум төгрөгийг зээлийн хүүгийн татаас шийдвэрлүүлсэн юм.

Энэ нь сумандаа, бүс нутагтаа хөнгөн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл бий болгох, үйлдвэрээ шинэчлэхэд энэ хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжтой.

“

Уул уурхайг орлох гол экспортын бүтээгдэхүүн бол ноолуур

“Цагаан алт”

хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкны **18** хувьтай зээлийн **12**-ыг нь төрөөс дэмжлэг болгон хөнгөлнө

Ийнхүү **ДЭД БҮТЭЦ** болон **САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ**

нь шийдэж өгснөөр бүс нутгийнхаа эдийн засгийг тэлэх боломжийг цогцоор нь бүрдүүлж өгч байгаа юм.

Монгол Улс жил тутам 9-10 мянган тонн түүхий ноолуур бэлтгэдэг. Энэ дэлхийн зах зээлийн 40 орчим хувь юм. Бид ноолуурын зах зээлийн маш том тоглогч болох боломжтой ч яг одоогийн байдлаар техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал үйлдвэрлэлийн өнөөгийн түвшинтэй харьцуулахад хангалтгүй байгаа учраас “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд угааж самнаад гаргадаг байдлаас утас ээрэх шугамаа өргөтгөх хүртэлх шинэчлэлийг хийхээр зорьж зээлийн бодлогоо хэрэгжүүлж байгааг тодотгох нь зүйтэй.

Бүсийн хөгжлийг дэмжих хууль эрх зүйн орчны томоохон өөрчлөлт бол үйлдвэрийн чөлөөт бүсэд татварын хөнгөлөлт үзүүлэх явдал. Үйлдвэрлэл технологийн паркийн болоод бусад холбогдох хуулиудад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Үүний нэг тод жишээ Хувь хүний орлогын албан татварын тухай хууль. Улаанбаатар хот дотор болон Улаанбаатараас 1000 км-ийн дотор, 1000-аас дээш км-ийн зайд ажиллаж амьдарч буй иргэд гэсэн шатлалаар 10 хувь байсан татварын хэмжээг 1-5 хувь болгох өөрчлөлтийг хийхээр хуулийн төслөө боловсруулан удахгүй УИХ-д өргөн барихаар зэхэж байна.

Өдгөөгөөс нэг жилийн өмнө залуусынхаа орон нутагт ажиллаж, амьдрах үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллахаа амлаж байсан бол өнөөдөр ийнхүү тодорхой түвшинд үр дүнд хүрч, ажил урагшилж буй нь сайшаалтай. Бүс нутаг дахь боомтуудын хүчин чадлыг өргөтгөн, экспорт, импортын бараа бүтээгдэхүүний нэвтрэлтийг нэмэгдүүлснээр баруун бүсийн хөгжил, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх бололцоог бүрдүүлэх зорилгод ирэх жил илүүтэй төвлөрөн ажиллах болно.

“


**Ажлын байр
нэмэгдүүлэх
хамгийн бодих
салбар бол
хөнгөн үйлдвэр**



Чиг үүргийн давхардалтай 29 зөвлөл, хороодыг татан буулгаж төсвөөс 41.6 тэрбумыг хэмнэлээ




УИХ-ын гишүүн Б.Энхбаяр, П.Сайнзориг нарын хамтаар төрийн оновчгүй хийгээд, данхар бүтцийг цэгцлэх талаарх өмнөх Ерөнхий сайдад удаа дараа тавьсан санал, шаардлага, асуулга шинэ Засгийн газар эмхлэн байгуулагдсанаар шийдвэрлэгдлээ.



Асуулгад салбар дундын үйл ажиллагааг нь зохицуулах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөл, хороо, комисс байгуулах эрх Засгийн газар болон Засгийн газрын гишүүнд байв. Гэтэл хуулиар **чиг үүрэг нь тодорхойлогдоогүй** яам, агентлагийн чиг үүрэгтэй давхардаж байгуулагдсанаар төсөвт шаардлагагүй зарлага үүсгэснийг тодотгож байв.

Засгийн газар бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх зорилтын хүрээнд долоодугаар сарын 9-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар 29 хороо зөвлөлийг татан буулгах шийдвэр гаргалаа. Ингэснээр төсвөөс жил бүр 41.6 тэрбум төгрөг хэмнэгдэхээр болов.



УИХ-ын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж, хариуг хуульд заасан хугацаанд авахыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан байдаг.



З.МЭНДСАЙХАН

УИХ-ын гишүүн


Бүтцээ өөрчлөхгүйгээр цааш явах боломжгүй

Сайд нь салбараа УИХ, Ерөнхий сайдынхаа өмнө хариуцаж чадахаа болиод үндэсний хороодоор уялдаа холбоог хангадаг бүтэц бий болж, орон тоо, урсгал зардлыг тэлээд байдаг. Гэтэл нийгэмд хэв журмыг сахиулах, ард иргэдийнхээ аюулгүй тайван байдлыг хангадаг Цагдаагийн байгууллагын дарга нь 6000 орон тоогоор хүн хүч дутмаг байгаа зовлон яриад сууж байна. Төр цомхон бөгөөд чанартай бүтэцтэй байх ёстой.

Сүүлийн 12 жилийн байдлаар төрийн албан хаагчдын тоо

40

хувиар өсөж



230.000

мянгад хүрээд байна.

Иймд чиг үүргийг оновчлол, үр ашгийн өсөлт бий болгох, технологи нэвтрүүлэх, төсвийн хэмнэлт зэргийг хослуулснаар 2026 онд буюу эхний ээлжид төрийн албыг 9 хувиар цомхотгох тооцоолол хийгээд байна.

“Цагаан алт” хөтөлбөрийн хэрэгжилт, бодлогын залгамж чанарыг хангахад анхаарна



Ж.ЭНХБАЯР

УИХ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайд

“Цагаан алт” хөтөлбөр задгайрахгүй, харин ч амжилттай хэрэгжинэ

Хөнгөн үйлдвэрийн салбарт сэргэлт авчрах үндэсний хөдөлгөөн их ажил дөнгөж эхэлж байна. Өнгөрсөн хугацаанд техник технологи, тоног төхөөрөмжийн том дэвшил гаргаж чадсан. Дэлхийн малын гаралтай түүхий эдийн зах зээлийн төлөв ч өөдрөг байгаа. Энэ үеийг бид ашиглах ёстой. Одоо “Цагаан алт” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх компаниуд өнгөрсөн 30 жилд салбартаа шалгарч, туршлагажиж үлдэж чадсан аж ахуйн нэгжүүд бий.



Малын түүхий эд боловсруулах бүтээгдэхүүн, үйлдвэрүүд хангалттай хүчин чадалгүй байгаа учраас малчдын орлого тогтворгүй, залгамж халаа нь ховордох, хөдөө нутаг маань эзэнгүйдэх асуудал үүсээд буй энэ цаг үед Засгийн газар, УИХ-аас энэ чиглэлд 2 хөтөлбөр баталсны нэг нь миний бие Ерөнхийлөгчийн Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил хариуцсан зөвлөх байхдаа санаачилсан “Цагаан алт” хөтөлбөр бөгөөд эхнээсээ үр шимээ өгч байна.

Энэ нь салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих, үйлдвэрлэл, борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах зэрэг дөрвөн үндсэн чиглэлээр 18 оролцогч талуудын хамтын ажиллагааны хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлнэ. Тухайлбал, Ноолуурыг самнаад гаргах бодлогын хүрээнд хилийн цаана аваачиж самнаад дэлхийн зах зээл рүү гаргадаг байсан хятадууд буюу гуравдагч худалдан авагч ченжүүд өнөөдөр манай үндэсний үйлдвэрүүдтэй хэлцэл хийж эхэллээ. Үүнийг дагаад мөнгөний урсгал орж ирж буй нь сайн үр дүн мөн.


2024 онд 404.1 сая ам.долларын ноолуур экспортолж, түүхий ноолуурын 50-аас дээш хувийг үндэсний үйлдвэрүүд худалдан авч байна.

“Цагаан алт” үндэсний хөтөлбөрийн нийт төсөв

2.19 их наяд төгрөг бөгөөд үүнээс

680

гаруй тэрбум төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.





З.МЭНДСАЙХАН

УИХ-ын гишүүн

Хамгийн том экспорт хийх боломжтой дайвар бүтээгдэхүүнийг банкны зээлийн жагсаалтад оруулах ёстой

Баруун аймгийнхны малчдын гол орлого болсон ноолуурыг авахад нэмэлт санхүүжилт олгох, мөн бүс нутгуудад анхан шатны боловсруулах үйлдвэр барих “Цагаан алт” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад яам анхаарч ажиллаж байгаа нь талархуштай. Гэвч нэг зүйлийг анхааралдаа аваарай. Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн банкны зээлийн жагсаалтад ороогүй байна. Өлөнгөөс эхлэн энэ төрлийн дайвар бүтээгдэхүүний үйлдвэрүүд маань хамгийн том экспорт хийх боломжтой.

“

Сүүлийн 4 жилд Монгол Улс “Цагаан алт” хөтөлбөрийг дэмжсэн 2 хууль, УИХ-ын 3 тогтоол, Засгийн Газрын 2 тогтоол батлан хэрэгжүүлж байна.

Мөн хөнгөн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, импортыг орлох, экспортын чиг баримжаатай, үнэ цэн шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлнэ.




Уг хөтөлбөрийн хүрээнд **119** үйлдвэр,
412.75 тэрбум төгрөгийн хүүтэй дэмжлэгтэй зээлд хамрагдаж, техникийн зохицуулалт хэрэгжсэнээр самнасан ноолуур экспортолж эхлэв.
 Үр дүнд нь **8000** ажлын байр шинээр бий болно.

“Халзан бүрэгтэй”-н сонголыг зохион байгуулж ИРГЭДИЙН МЭДЭХ ЭРХИЙГ хангана



Ховд аймгийн Мянгад суманд орших газрын ховор элемент агуулсан “Халзан бүрэгтэй” төслийн үйл ажиллагааг нутгийн иргэд, олон нийтийн зүгээс байгаль экологид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж үзэн эсэргүүцэж, үндсэн хуулиар олгосон эрхээ хамгаалуулах, төр засгийг үүргээ хэрэгжүүлэхийг 2 жилийн турш шаардсаар байна. Миний бие салбарын яам, сайд болоод холбогдох төрийн байгууллагуудад энэ асуудлыг албан ёсоор удаа дараа тавьснаар тодорхой үр дүнд хүрлээ. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд тус ордыг ашиглахад тухайн бүс нутгийн хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэл, түүнийг бууруулах талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь тодорхойгүй байсаар өнөөдрийг хүрсэн юм. Иргэд мэдэх эрхтэй, төр мэдээллээр хангах үүрэгтэй.



“
Төр олгосон тусгай зөвшөөрлүүдээ хэрхэн хамгаалах бодлого барьдгийг тодорхой болгох нь зүйтэй. Төр түүнийгээ халмаалдаг байх ёстой.


2024 оны наймдугаар сарын 28-ны өдөр Засгийн газрын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваанд АСУУЛГА тавив.



Тус орд нь Лантан (La), Церий (Ce), Иттри (Y), Диспрози (Dy), Неодим (Nd) зэрэг газрын ховор элемент агуулсан 5.0 сая тонн хүдрийн нөөцтэй

Миний бие ард түмний элч, төлөөлөгч байх үүргийнхээ хүрээнд үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр, хууль зөрчиж олгосон гэх аймгийн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт хүчинтэй байгаа эсэх, ард иргэдийн саналыг авсан эсэх, цацраг идэвхт бодисын хэмжээ хүн амьтан, хүрээлэн буй орчинд аюулгүй гэсэн дүгнэлт гарсан эсэх зэрэг 8 асуулт бүхий асуулгыг тавьсан ч хариу ирүүлээгүй юм.

Тиймээс олон нийтэд нээлттэй ил тод болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг дүгнэх, хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор УИХ-ын “**Ерөнхий хяналтын сонголт**” явуулах зайлшгүй шаардлага байгааг УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлж ирэх **есдүгээр сарын 23-ны өдөр** зохион байгуулах шийдвэр гаргуулаа.



НД-ын хуулийн өөрчлөлтөөр Иргэдийн орлого нэмэгдэж ААН-үүдийн үйл ажиллагаа батажна

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай
Өргөн барьсан огноо: 2025.05.09



Б.Түвшин нарын гишүүдийн хамтаар иргэн, хуулийн этгээдийн ажил, бизнес, үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, ачааллыг бууруулах, ашиг орлого, өрсөлдөх чадвар, ажлын байр нэмэгдүүлэх, далд эдийн засгийг ил болгож, чөлөөт зах зээлийн харилцааг тэлэх, үүний үр дүнд татвар, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагад тулгуурлан **Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсрууллаа.**

Төсөлд:

1. Монгол Улсын өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй Иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулах ажил, үйлчилгээ эрхлэх хүнийг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчаас хасаж, гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хасах;
2. Ажил олгогч ажилтанд олгох хоол, унаа, орон сууцны ашиглалтын төлбөр, түлээ, нүүрс худалдан авахад зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлтийг цалин, түүнтэй адилтгах орлого болон нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хасах;
3. Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг ажилтны нэгэн адилаар тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээ тогтоохоор тусгав.




Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) гишүүн 38 орноос 34 нь буюу нийт гишүүдийн 90 орчим хувь нь ажил олгогчийн төлөх шимтгэлийн дээд хязгаарыг хуульчилсан байдаг

АЛСЛАГДСАН БҮСИЙН ИРГЭД ХХОАТ-Т 10 БИШ 1 ХУВИЙН ТАТВАР ТӨЛДӨГ БОЛНО



Алс баруун бүсийн иргэд өнөөдөр сарын дундаж цалингийн хэмжээгээр хамгийн бага буюу улсын дунджаас хамгийн бага орлоготой мөртлөө өргөн хэрэглээний барааг хотынхтой харьцуулахад хэт өндөр үнээр худалдан авч байна.

УИХ-аас Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих талаар урт болон дунд хугацааны төрийн бодлого, хууль тогтоомжийг батлан, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэн ажиллаж ирсэн хэдий ч орлого, хөгжил, бараа бүтээгдэхүүний үнийн ялгаатай байдлаас үүдэн Улаанбаатар хот руу шилжин суурьших иргэдийн эрмэлзэл буурахгүй байгаа тул бидний хэдэн гишүүд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсрууллаа.



Үндэсний статистикийн хорооны мэдээллээр ажиллагсдын сарын дундаж цалингийн хэмжээгээр баруун бүс хамгийн бага буюу улсын дунджаас 22.8 хувиар бага байна.

/2024 оны 2 дугаар сарын Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын танилцуулгад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан/

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах бодлого баримтална, хөдөө орон нутгаас Улаанбаатарыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, төвлөрлийг сааруулах зорилгоор бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлнэ гэж тусгасныг үндэслэж дараах 3 шатлалаар албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого болон шууд бус орлогын **албан татварын ногдол хувь хэмжээг бууруулах** өөрчлөлтийг хийв.



1. Нийслэл Улаанбаатар хотын оршин суугч 5 хувь.
2. Улаанбаатар хотоос 1000 км хүртэл хол алслагдсан бүс нутгийн оршин суугч 3 хувь.
3. 1000 км-ээс дээш алслагдсан бүс нутгийн оршин суугч 1 хувь.

Ингэснээр алслагдсан бүс нутгийн нийгэм, эдийн засгийн олон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хөдөөгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх боломж бүрдэх юм.


Улаанбаатар хотод сүүлийн 3 жилийн хугацаанд жил бүр **31-37** мянган иргэн шилжин ирсэн бол **7-16** мянган иргэн шилжин явжээ.

Жаран жил дуншсан Эрдэнэбүрэнгийн УЦС-ын төслийн санхүүжилт шийдэгдлээ




Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын нэг тулгуур бол эрчим хүчний салбар. Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн дөрвөн сумыг хамарсан 28000 га талбайд баригдах Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц нь баруун бүс болон Алтай-Улиастай эрчим хүчний системийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг тэглэн, ногоон эрчим хүчээр 100 хувь бүрэн хангаж, их ачааллын үед Төвийн эрчим хүчний системийг дэмжин ажиллах бололцоог бүрдүүлэх боломжтой тул хамтарсан засгийн газрын хэрэгжүүлэх 14 мега төсөлд багтсан юм.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын төслийн энэ хүрсэн түүх



Ийнхүү төслийн баг хайгуул судалгаагаа хийж, нутгийн иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсан ч зөвшилцөлд хүрч бүтээн байгуулалтын ажил эхэлсэн. 2024 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр тусгайлсан зээлийн хэлэлцээрийг БНХАУ-ын ЭКСИМ банкттай байгууллаа.

A man with a beard and glasses, wearing a dark suit and tie, is seated at a conference table. He is speaking into a microphone. The background is blurred, showing other people and a conference room setting. A coffee cup is visible on the table in front of him.

Миний бие 2022 оны наймдугаар сард “Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын төсөл”-ийг хариуцан ажиллахаар томилогдож байв. Улмаар Ерөнхийлөгчийн Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил хариуцсан орон тооны зөвлөх байх үедээ уг станцыг түшиглэж хөнгөн үйлдвэр хөгжүүлэх бодлогыг боловсруулахад оролцож, төслийн явц, хэрэгжилтэд хяналт шаардлага тавин ажиллаж байна. Эрдэнэбүрэнгийн УЦС Тайширынхаас 10 дахин өндөр буюу 90МВт-ын хүчин чадалтай. Үүний 50МВт-аар нь баруун таван аймгийг бүхэлд нь хямд, найдвартай эрчим хүчээр хангаж, хараат байдлыг хална. Цаана нь 40МВт-ын нөөц үлдэх тооцоололтой. Энэхүү нөөцийг, Үйлдвэр технологийн парк барих зэргээр аж үйлдвэр, хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэхэд чиглэлд ашиглах бүрэн бололцоотой.

Баруун бүсийн иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангах ажил бодлогын түвшинд яаралтай хийгдэх ёстой

Хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны эх үүсвэрээр хангах нь нэн тэргүүний асуудал. Иймд 2021-2025 онд Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд Ногоон хөгжил бодлогын хүрээнд нийт хүн амын 85-аас доошгүй хувийг шаардлага хангасан ундны эх үүсвэрээр хангахыг тусгасан.

Гэвч 2025 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 50 хувийн хэрэгжилттэй байна. Тамгын газрын үнэлгээгээр 30 хувь гэж дүгнэсэн нь тайлагналт хангалтгүй байгаагийн илрэл юм. **Говь-Алтай аймгийн урд зүгийн сумд, Ховд аймгийн 4 сум Хар ус нуурын усыг цэвэршүүлж ууж байна.** Ундны цэвэр усаар хангах нь иргэдийн эрүүл мэнд, насжилттай шууд холбоотой тул энэ чиглэлийн бодлогыг яаралтай хэрэгжүүлэхийг шаардаж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтугагаас тодруулга авав.



Д.АМАРБАЯСГАЛАН
УИХ-ын дарга

Чуулганы завсарлагааны үеэр орон нутагт ажиллаад явж байхад ундны усны чанар маш муу байгааг иргэд ярьж байна. Сумын түвшинд хатуулгыг нь арилгасан шүүлтүүртэй ус ууж байгаа сум гэж бараг алга. Өвлийн цагт Увс аймгийн Зүүн хангай, Тэлмэн сумдын худаг нь ажиллахаа больчихдог учраас иргэд мөс, цас хайлуулж уудаг ийм нөхцөлд амьдарч байна. Тиймээс усны худаг дээр нь шүүлтүүр тавих, усны судалгааг нэгдсэн зохион байгуулалттайгаар хийх, цаашлаад өвөл, зуны аль ч улиралд усны дутагдалд ордоггүй байх чиглэлд дорвитой арга хэмжээ авах нь зүйтэй.



УИХ-ын гишүүн
С.Одонтугая

Ховд, Завхан, Дорнод аймгийг хамарсан Хар нуур, Ховд, Үенч, Бодонт, Хяргас нуур, Завхан сав газрын усны менежментийн нэгдсэн төлөвлөгөөг батлуулахаар ажиллаж байна. Энэ жил Говийн бүсийн 44 суманд иргэдийн ундны усны чанарыг тодорхойлох ажлыг хийхээр төсөвт суулгасан. Усны асуудал дээр улсын төсөв хангалттай тавигддаггүй бодит үнэн бий.

Монголын хөнгөн үйлдвэр эрхлэгчдийг ШИНЭ ХОВД ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК РУУ ТАТЪЯ

Баруун бүс нийт мал сүргийн 24 орчим хувь буюу 15 орчим сая толгой малтай, түүхий эдийн нөөц бүрдүүлэх боломжтой боловч төвийн үйлдвэрлэлийн бүсээс алслагдмал оршдог. Ховд аймгийн хувьд баруун бүсийн тулгуур төв, хилийн 2 боомттой зах зээл харьцангуй нэвтрэх боломж сайтайг харгалзан үзэж үйлдвэрлэл, технологийн парк байгуулахаар шийдвэрлэсэн. Улаанбаатар хотоос 1460 км зайтай Ховд аймгийн Жаргалант суманд 100 га газарт байгуулагдах уг паркийн хөгжил, үр нөлөөг идэвхжүүлэхийн тулд Цагаан алт хөтөлбөрөөр дамжуулан хөнгөн үйлдвэр эрхлэгчдийг баруун бүс нутаг руу татах, салбараа нээхэд нь зориулж хөнгөн үйлдвэрийн зөвлөгөөний Баруун бүсэд зохион байгуулж өгөх хүсэлтээ Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд илэрхийллээ.



“Миний бие Ховд үйлдвэр технологийн паркийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг 2024-2025 оны төсөвт суулгуулж, үлдэснийг нь 2026 оны төсөвт оруулах саналыг тавин ажиллаж байна.



Ж.ЭНХБАЯР

УИХ-ын гишүүн, ХХААХҮ-ийн сайд

Уг бүтээн байгуулалтад зориулан энэ жил 18 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээр төсөвлөсөн. Дэд бүтцийн ажил хийгдээд дуусна. Одоо бид хувийн хэвшлийг парк байгуулах, орчин бүрдүүлэх, урих, хөрөнгө оруулахад таатай орчныг бүрдүүлэх ажлыг хийх ёстой. “Цагаан алт” хөтөлбөр энэ жил гараанаасаа гарч 2028 он хүртэл үргэлжилнэ. Ирэх жил хаврын тариалалтын үеэр Ховдод очихдоо энэ ажлыг хамтатган зохион байгуулах боломжтой. Тантай хамтран ажиллах болно.

Уг парсад жилд **1 сая** ширхэг арьс шир боловсруулах, жилд **3000 тн** ноос, **300 тн** ноолуур боловсруулах зэрэг хүчин чадалтай үйлдвэрүүд баригдана.



Парк байгуулснаар **2271** байнгын, **1100** түр ажлын байр шинээр бий болж, экспортыг оруулаад, жилд дунджаар **132** сая ам.долларын орлого олж, ДНБ-д **636,4** тэрбум төгрөгийн орлого оруулах боломжтой

ИРГЭДЭЭ СОНСДОГ ТӨРИЙГ БЭХЖҮҮЛЭХ ЭХНИЙ АЛХАМ БУЮУ **УТААНЫ СОНСГОЛ**



Ардчилсан парламентын иргэдээ сонсдог төр болох зорилго “Утааны сонсгол” буюу Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл сэдвээр ерөнхий хяналтын сонсгол хийснээр нэг алхам урагшлав.

Нийтийн өргөдөл, гомдлын систем petition.parliament.mn-д Батбаатарын Мөнгөнхишиг иргэний үүсгэсэн “Утааны сонсгол хийцгээе! өргөдөлд 71 мянган иргэн гарын үсэг зурж нэгдсэнээр агаарын бохирдлоос үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, зуух түлшний стандарт, эрх зүйн орчин, энэ чиглэлээр хийж хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр, түүний хэрэгжилт, санхүүжилтийн асуудлыг улс орны түвшинд, нээлттэй, иргэдийн оролцоотой хэлэлцүүлэв. Үр дүнд нь 13 ажлын багтаасан УИХ-ын тогтоолыг батлан Засгийн газарт чиглэл болгон хүргүүлээ

- **2024.11.27** Утааны сонсгол хийцгээе! өргөдлийг petition.parliament.mn-д нээв
- **2025.01.15** “Агаарын бохирдол-Хүн амын эрүүл мэнд”-ийн асуудлыг хэлэлцэв
- **2025.01.22** “Зуух, түлшний хяналт, стандартын асуудал”-ыг хэлэлцэв.
- **2025.01.29** “Эрх зүйн орчин, санхүү, хариуцлага”-ыг шүүн нягтлав.
- **2025.02.03** Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛ зохион байгуулав.
- **2025.04.15** Утааг багасгах шийдэл бүхий 13 заалттай УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д танилцуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо шийдвэрлэв.



Давхардсан тоогоор **194** иргэн, төрийн байгууллагын **93** албан тушаалтан оролцов. **75** иргэн асуулт асууж, **28** иргэн танилцуулга хийх үйл явцыг орон даяар шууд дамжуулав.



УИХ-ын гишүүн **З.Мэндсайхан**:

Том төслүүд хэрэгжиж эхэлтэл аль айлын яндангаас утаа гарч байгааг мэддэг байх түвшний хяналт хэрэгтэй.

Миний бие Ерөнхий хяналтын 2025.02.03-ны өдрийн сонсголд “Стандарт, хяналт” (Зуух, түлшний технологи) сэдэвт хоёр дахь хэлэлцүүлгийг удирдан явуулав.

Энэ үеэр Эрдэмтэн судлаачид, иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 70 гаруй хүн оролцож, 28 хүн зуух, түлшний технологийн шийдлүүдийг танилцуулахад:

- Дулаалга бол гол шийдэл
- Гэр хороололд хэсэгчилсэн болон бие даасан дэд бүцийг дэмжих
- Шахмал түлшний түүхий эд болох мидлингийг сольж, үнслэг багатай сайн чанарын нүүрс ашиглах
- Цахилгаан халаалт ашиглах
- Нүүрснээс хийн түлш үйлдвэрлэх
- Модлог, био түлш ашиглах
- Зуух, пийшингийн технологийг хөгжүүлж, аюулгүй ажиллагааг дээшлүүлэх саналууд давхцаж байв.

Урт хугацаандаа гааз, дахин төлөвлөлтийн асуудлууд мэдээж үр дүнгээ өгнө. Харин тэр хүртэлх хугацаанд нийслэлийг хатуу түлшний хэрэглээнээс гаргаж хийн болон бусад төрлийн түлшний хэрэглээнд нэвтрүүлэхдээ нэгдсэн стандарт бүхий шаардлага хангасан түлшийг иргэд өөрсдөө сонгох эрхийг хангаж, ахуйн орчин нөхцөлд нь эрсдэлийн болон өртөг үр ашгийн үнэлгээг хийсэн байхад анхаарахыг Засгийн газарт өгсөн чиглэлд онцгойлон тусгасан юм.



Ж.ЧИНБҮРЭН

УИХ-ын гишүүн

Монгол Улсад иргэн болж төрөх ёстой хэдэн мянган амь утаанаас болж сүйдэж, угаарын хийн хордлогоор 779 иргэнээ алдсан бодит тоог бид нийтэд зарлалаа. Нийслэлээс 32 мянган зуух авах тендер зарлаж, гэр хорооллын айлуудад тараахыг зогсоосон нь уг сонсголын том үр дүн, нөлөөллийн ажил боллоо. Мөн угаартсан иргэдэд нөхөн төлбөр олгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, тухайн чиглэлийн төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангаж хариуцлагыг нэмэгдүүлэх бодитой өөрчлөлтийг бий болгоно.

126 гишүүнтэй парламентын анхны Хянан шалгах түр хороо Оюутолгойн асуудлаар байгуулагдлаа

Хуулийн нэр: УИХ-ын Хянан шалгах Түр хороо байгуулах тухай тогтоолын төсөл
Батлагдсан огноо: 2025.07.02



Тогтоолын төсөлд “Оюутолгой стратегийн ач холбогдол бүхий бүлэг ордын хил заагт Канад Улсын хөрөнгө оруулалттай “Онтрэ” ХХК-ийн эзэмшилд буй “ШИВЭЭ ТОЛГОЙ” болон “ЖАВХЛАНТ” ашиглалтын тусгай зөвшөөрлүүд хамаардаг. Уг хоёр тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах газрын хэвлийн баялгийг ашиглахад МУ-ын эрх ашгийг хангахтай холбоотой гэрээг өнөөдрийг хүртэл байгуулаагүй ирсэн. Харин шинэ 126 гишүүнтэй парламентын анхны Хянан шалгах түр хороо Оюутолгойн бүлэг ордын ашиглалтад МУ-ын эрх ашгийг хангуулах, үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр УИХ-ын тогтоол амжилттай батлагдлаа.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай УИХ-ын тогтоолын төсөлд

■ Парламентад суудалтай **5** намын намын **89** гишүүн гарын үсэг зурлаа.



■ Түр хороо үндсэн 2 чиглэлээр ажлаа 6 сарын дотор явуулна.

Нэг



Оюутолгой стратегийн бүлэг ордын хил заагт албан ёсоор орсон Канадын хөрөнгө оруулалттай “Онтрэ” компанийн эзэмшилд байгаа Шивээ толгой, Жавхлантад 2 лиценз дээр Монгол Улсын эрх ашгийг хангуулж шинэ хөрөнгө оруулалтын гэрээ хийх, холбогдох санал дүгнэлт гаргаж хяналт шалгалтыг хийнэ.

Хоёр

Оюутолгой төслийн зээлийн хүү бууруулах дээр ажиллана. Хувь нийлүүлэгчдийн гэрээгээр 7 жил тутам зээлийн хүүгээ дахин авч хэлэлцэх эрхээ бид нар хэрэгжүүлж өнөөдөр 11,1% байгаа зээлийн хүүг олон улсын жишигт дөхүүлж зайлшгүй бууруулах ёстой.



БИЗНЕС ЭРХЛЭГЧ ХООРОНДЫН ШҮҮХИЙН МАРГААНЫГ ЗАРДАЛ БАГА, ТҮРГЭН ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛНЭ

Өнөөдөр манай улсад бизнес эрхлэх нөхцөл байдал түвэгтэй, бизнесийн маргааныг шийдвэрлэх цаг хугацаа удаашралтай байгаа. Үүний цаана бизнесийн эргэлт, мөнгөн хөрөнгө гацдаг, бизнес эрхлэгчдийн итгэлцэл эвдэрдэг. Иймд бизнес эрхлэгч хоорондын шүүхийн маргааныг зардал багатай, хялбар, түргэн шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх, өмгөөлөгч шүүх хуралдааныг үндэслэлгүйгээр хойшлуулдаг нөхцөлөөс зайлсхийх, шүүхийн шийдвэр нь биелдэг, гэрээний үүрэг хангагддаг байх нь нэн чухал байна.

Арилжааны болон дампуурлын харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Тухайлбал, нэн түрүүнд бизнесийн төлөөллийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал бий. Гэрээг бичгээр үйлдэнэ гэж хуульд тусгасан ч бизнесийн түншүүд гэрээгээ цахимаар үйлдэж, мөнгөө шилжүүлэн бараа материалаа солилцчихдог. Улмаар маргаан үүсээд шүүхэд очдог асуудал нь бизнесийн үйл ажиллагааг дэмжих бус, саатуулах үйлдэл болж буй!

“ Арбитр, эвлэрүүлэн зуучлах чиглэлийн хууль, эрх зүйн механизмуудыг тодруулж үзэх ёстой!

УИХ-ын гишүүн **З.Мэндсайхан:**
БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
СААРУУЛЖ БҮЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ
ШИНЭЧИЛНЭ

Манай улсад бизнес эрхлэх нөхцөл байдал түвэгтэй, бизнесийн маргааныг шийдвэрлэх цаг хугацаа удаашралтай байгаа. Тухайлбал, гэрээг бичгээр үйлдэнэ гэж хуульд тусгасан ч бизнесийн түншүүд гэрээгээ цахим хэлбэрээр хийн мөнгөө шилжүүлээд, бараа материалаа солилцчихоор шүүх асуудлыг буцаадаг. Энэ нь бизнесийн үйл ажиллагааг дэмжих бус, саатуулах үйлдэл болоод байгаа. Үүнийг өөрчлөхөөр зорьж байна. Түүнчлэн бизнесийн маргааныг зөвхөн шүүхээр биш шүүхийн бус журмаар шийдвэрлэх асуудлыг ярьж байна.

Арбитр, эвлэрүүлэн зуучлах чиглэлийн эрх зүйн механизмуудыг бид тодруулж үзэх ёстой.

Эцэст нь гарсан шийдвэрүүд хэрэгждэггүйгээс мөнгөн хөрөнгүүд гацаанд ордог. Энэ бүхнийг дампуурлын хууль тогтоомжтой уялдуулан авч үзэх ёстой.



Улсын аваргууд ТОДОРЛОО

“

Их алтайн шаргын талд цагийн цагт тариан түрүү халиурч, ургац арвин байхыг ерөөе!

Монголын уламжлалт баяр, цагаан сарын босгон дээр газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэн, орон нутагт ажлын байр бий болгож нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан тэргүүний тариаланчдын амжилтыг үнэлэн аварга тариаланчдыг шалгаруулдаг уламжлалтай билээ. “Улсын аварга тариаланч”-аар шалгарсан Говь-Алтай аймгийн Шарга сумын тариаланч Очирбатын Амартүвшиндээ хүндэтгэл үзүүлж, шагналыг нь гардууллаа.

Мөн Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд байгалийн нөөц, бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах, малын тавлаг байдлыг хангах, тогтвортой хөгжүүлэх, монгол малын ашиг шим болон чадавхыг бэхжүүлэн бэлчээрийн уламжлалт соёлыг хадгалах, улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулж байгаа малчдын хөдөлмөрийг үнэлж “Улсын аварга малчин”-аар шалгаруулан алдаршуулах, тэдний тэргүүн туршлага, бүтээлч ажлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, залуу малчдад үлгэр дууриал болгоход энэхүү шагналын зорилго оршдог билээ.

“Монгол улсын аварга малчин” хэмээх эрхэм хүндтэй цол хүртсэн Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Тунгалаг багийн



малчин Дашбатжавын Нямсүрэн, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин Лувсан-Осорын Отгонбаяр, Ховд аймгийн Чандмань сумын Жаргалант багийн малчин Батчулууны Эрдэнэбаатар, Ховд аймгийн Дөргөн сумын Аргалант багийн малчин Чилаажавын Чулуунхорол, Говь-Алтай аймгийн Тонхил сумын Тамч багийн малчин Жүгдэрийн Баатаржав нарт болон Монголын Радиогийн


нэрэмжит “Алтан төлийн эзэн” болсон Ховд аймгийн Мянгад сумын Баянбулаг багийн малчин Баттулгын Бадам-Ёндоны гэр бүлд шагналыг нь гардуулан өглөө.

“

Буянт малын буян хишиг улам ихээр арвижин, арван цагаан буян нь өнө мөнхөд дэлгэрэх болтугай!

Малчин өрхийн **1 ХҮҮХЭД** ҮНЭГҮЙ МЭРГЭЖИЛ ЭЗЭМШИНЭ

Малчны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
Хэрэгжиж эхэлсэн огноо: 2025.01.01



Үндэсний статистикийн
хорооны мэдээллээр
2025 оны эхний хагас
жилд дотоодын нийт
бүтээгдэхүүн

5.6

хувиар өссөн.

3.6

Үүний
хувийн өсөлтийг хөдөө
аж ахуй дангаараа
бүрдүүлсэн.

Уул уурхайн бүтээгдэхүүнээс хамааралтай манай улс дэлхийн зах зээлд нүүрсний үнэ огцом унаснаар эдийн засгийн тогтворгүй байдалд ороод буй. Гэсэн ч эдийн засгийн эргэлтийг хэвийн түвшинд барихад хөдөө аж ахуйн салбар гол нөлөөг үзүүлээд байна.

Учир нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар “Атрын IV аян”, “Цагаан алт”, “Хүнсний хувьсгал” хөтөлбөрүүдийнхээ хүрээнд шинээр 58 мянган ажлын байр бий болгож чадсан нь уг үр дүнг авчрав.

Тэгвэл төр хөдөө аж ахуйн салбарын суурь болсон МАА-аа, малчдын залгамж халааг бэлтгэх чиглэлд маш чухал шийдвэр гаргасан нь **малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан өрхийн нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй суралцуулах** байв. Санхүүжилтийн эх үүсвэрийг Боловсролын зээлийн санд тусгаж өгснөөр энэ хичээлийн жилээс эхлэн уг хуулийн заалт биеллээ олж байна.

Суралцагч нь нийтлэг шаардлагаас гадна төгссөнөөс хойш орон нутгийн байгууллагад, **гурван жил** нийслэлд **таван жил** мэргэжлээрээ тогтвортой ажиллах нөхцөлийг хүлээн зөвшөөрснөөр уг боломжийн эзэн болох нь.



2025 оны Улсын Төсөв

иргэдийн нийгэм хамгааллыг дэмжив



Монгол Улс 2025 оны төсвөө 33,5 их наяд төгрөг байлгахгаар төлөвлөж төсвийн төслөө 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлав.

Үүнээс 25.3 их наяд нь цалин тэтгэвэр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ, татаас, шилжүүлэх зэрэг урсгал зардал, 8,3 их наяд нь хөрөнгийн болоод хөрөнгө оруулалт, шинэ бүтээн байгуулалтын зардал байхаар тооцжээ.

ТӨСВИЙН БОДЛОГЫН 2025 ОНЫ ГОЛ ТАВАН ЧИГЛЭЛ



2025 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО



2025 онд Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000 төгрөг болгон нэмэгдүүлэв

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10-р сарын 7-ны хурлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 660 мянган төгрөг байгааг 20 хувиар нэмэгдүүлэн цагийн 4715 буюу сард 792 мянган төгрөг болгохоор шийдвэрлэж, 2025 оны дөрөвдүгээр сарын 1-ээс мөрдөж эхэлсэн билээ.



Мөн Монгол Улс нийгмийн бодлогын хүрээнд 2025 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн

- 226 мянган төрийн албан хаагчийн цалинг **6** хувиар
- 510 мянган ахмадынхаа тэтгэврийг:

1. Дундаж тэтгэврийн хэмжээ **875,800,**
2. Бүрэн тэтгэвэр болон цэргийн албан хаагчийн тэтгэврийн доод хэмжээ **689,000,**
3. Хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ **572,000** байхаар нэмэгдүүлснээс гадна

ЖИЛД НЭГ УДАА

“Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонтой эхэд **400,000**
Эхийн алдар хоёрдугаар зэргийн одонтой эхэд **200,000**
төгрөгийн мөнгөн тусламжийг олгож эхлэв.

УИХ, Байнгын хороодын хуралдаанд хэлсэн ОНЦЛОХ байр суурь

■ З.МЭНДСАЙХАН

Газрын тос боловсруулах үндэсний үйлдвэр нь Хямд гэхээсээ илүүтэй Найдвартай хангамжийн асуудлыг шийднэ

2025.01.13, Монгол Улсын Засгийн газар болон Бүгд найрамдах Энэтхэг Улсын Экспорт-Импорт банк хооронд байгуулах зээлийн хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгээс, АБГББХ

“

2028 онд Үйлдвэр ашиглалтад орсноор өнөөдрийн байдлаар газрын тос олборлож буй компаниудын нийлүүлэлтийг хангаж дийлэх эсэх буюу нөөцийн асуудлыг нарийн тооцоолох шаардлагатай.



■ З.МЭНДСАЙХАН

Мал аж ахуйн салбарын экспортыг нэмэгдүүлэхэд бүс нутгуудад ТУСГААРЛАГДСАН ЭРҮҮЛ БҮС байгуулах шаардлагатай

2024.12.10, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон бусад хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлгээс, ТБХ

“

Мал бол үндэсний баялаг. Хөдөө аж ахуйн салбар, тэр дундаа мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд нэн тэргүүнд малын эрүүл мэндийн асуудлыг бодлогын түвшинд авч үзэх нь зүйтэй. Үүнийг жил бүр төсөвлөдөг вакцины мөнгөөр шийдэж чадахгүй учраас боомтууд дээр малын тусгаарлагдсан эрүүл бүсүүд байгуулах ажлыг яаралтай хийх ёстой юм.

■ З.МЭНДСАЙХАН

Заарт хархын байгальд тэнцвэртэй байдлыг хадгалах бодлого хэрэгжүүлж, иргэдийн зовлонг хөнгөвчилъе!

2025.04.30, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлгээс, БОХХААБХ

“

Ховд аймагт чононоос гадна Заарт харх гэж амьтан бий. Хар ус нуурын ай саваар нутаглаж буй айл өрхүүдийн өвөлжөө усан доогуур орж, их хэмжээний хохирол учруулж байна. Эдийн засгийн зохицуулалт хийхгүй байгаа учраас хүмүүс агнахгүй байна. Тиймээс салбарын яам энэ амьтны байгальд тэнцвэртэй байдлыг хадгалах бодлогыг боловсруулж, яаралтай хэрэгжүүлэх хэрэгтэй.

■ З.МЭНДСАЙХАН

Усалгаатай тариалангийн төслийг баруун аймгуудад дахин хэрэгжүүлье!

2025.07.07, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийн хэлэлцүүлгээс, БОХХААБХ

“

Ховд аймагт 2500 га газарт Азийн хөгжлийн банк ТЭЗҮ, газар зүйн заалт дээр судалгаа хийсний дүнд баруун бүсийг усжуулах, хүнсний ногоогоор хангах төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан байдаг. Гэтэл үүнийг Төвийн бүс рүү шилжүүлчихсэн. Монгол Улсын Хөдөө аж ахуйн яам бол улсын хэмжээнд бодлогоо авч явах ёстой. Тиймээс бүс нутгуудад дутагдаад байгаа ХАА-н салбарын бодлогыг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой болгож өг гэж хэлмээр байна.

■ З.МЭНДСАЙХАН

Монгол “товарлаг” адууг бий болгохыг дэмжиж байна

2025.06.24, Малын генетик нөөцийн тухай хуулийн биелэлтэд хяналт шалгалт хийх, Монгол үүлдэр, омгийн адууны удмын санг хамгаалах асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийн хэлэлцүүлгээс, БОХХААБХ

“

Монголчуудын хамгийн том товарлаг байдлыг бий болгох мал, махны экспортод түлхэц үзүүлэх субъект нь адуу. Импортын асуудлаас болж хурдны чиглэл рүү хэт явсаар генетик нөөц өөрчлөгдсөн. Тиймээс үржлийн адууг хилээр импортлохыг 10 жилээр хориглохыг дэмжиж байна. Энэ хугацаанд байгаль, цаг ууртаа дассан, хурдан бөгөөд товарлаг адуугаа дахин бий болгох боломжтой.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо 2024-2025 оны хавар,
намрын чуулганы товч тайлан



УИХ-ын гишүүн З.Мэндсайхан 126 гишүүнтэй анхны парламентад Төсвийн байнгын хорооны гишүүнээр ажиллаж Монгол Улсын эдийн засгийн сорилтын цаг үед төсөвтэй холбоотой хууль, эрх зүйн шинэчлэлийг хийх үйл хэрэгт гар бие оролцов.



Байнгын хорооны
хуралдаан **44**



Иргэдээс ирүүлсэн
өргөдөл гомдол **21**



Байнгын хорооны
тогтоолын төсөл **24**



Хэлэлцсэн
асуудал **103**



УИХ-ын
тогтоолын төсөл **28**



Хариу өгч
шийдвэрлэсэн **21**



Хуулийн
төсөл **37**



Хянаж
хариу өгсөн **122**



ААН, байгууллагаас
ирүүлсэн албан бичиг **122**



Монгол Улсын 2025 оны төсвийн хэлэлцүүлгүүдийн үр дүнд төсвийн хэт тэлэлтийг зогсоож чадлаа. Цаашдаа ч Улсын Их Хурлын гишүүд, улс төрийн түвшинд хоёроос гурав дахин нэмэгддэг төсвийн хэт тэлэлтийг хязгаарлахад нэгдмэл байр суурьтай байхаа илэрхийлсэн нь онцлох алхам болов.

Мөн 2025 онд Ирээдүйн өв сан, Үндэсний баялгийн санд 2.3 их наяд төгрөг төвлөрүүлэхээр тооцсоны зэрэгцээ цалин, тэтгэвэр тэтгэмжийг инфляцтай уялдуулж 6 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, улмаар төрийн албан хаагчийн цалингийн өсөлтөд шаардагдах 438 тэрбум төгрөг, тэтгэвэр тэтгэмжийн 301 тэрбум төгрөгийн хөрөнгийг төсөвлөлөө.

Татварын ерөнхий хуулийн хүрээнд бизнесийн салбар, аж ахуйн нэгжийнхэнд нааштай томоохон өөрчлөлт хийсэн нь санхүүгийн бичиг, баримтыг хурамчаар үйлдсэн нь нотлогдоогүй зэрэг хоёр асуудлаас бусад үед бизнес эрхлэгчийн мэдээллийг нийтэд ил, тод тавихаас сэргийлсэн, хамгаалсан зохицуулалтыг тусгасан ач холбогдолтой хууль батлагдсаныг онцлох нь зүйтэй.

Мөн түүнчлэн, уул уурхайн бүтээгдэхүүнээс хамаарал бүхий эдийн засагтай манай улсад нүүрсний үнэ огцом унаж тогтворгүй байдал бий болсон сорилтын үе байв. Иймд 2026-2027 оны төсвийн төсөөлөл, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай зэрэг хуулиудад өөрчлөлт оруулж баталлаа.

Гурван төгөлдөршил бодлогын хүрээнд УИХ-ын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор “Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн албан татварын хэмжээг нэмэгдүүлснийг хүчингүй болгох”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6.3-д заасан орлогод ноогддог албан татварын хэмжээг 1 хувь болгож бууруулах” талаарх нийтийн өргөдлийг тус Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцүүлсэн нь 126 гишүүнтэй анхны парламентын Хүн төвтэй, иргэний оролцоотой хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх зорилт биеллээ олж эхэлсний илрэл болов.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
2024-2025 оны хавар, намрын чуулганы товч тайлан



Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн салбартай бүхий л үйл хэргээрээ холбогдсон УИХ-ын гишүүн 3. Мэндсайхан өнгөрөгч 1 жилийн хугацаанд байнгын хорооны гишүүний хувиар малын эрүүл ахуйн асуудал, даатгал, адууны удмын сангийн асуудлуудад онцгойлон анхаарч, суурин газрын хүн амын эрүүл мэндийн гол дайсан болоод буй “Утааны сонсгол”-д гар бие оролцож, энэ чиглэлийн төрийн бодлогод хувь нэмрээ оруулав.



Байнгын хорооны хуралдаан 25

Хэлэлцсэн асуудал 61



УИХ-ын тогтоол 3



Хуулийн төсөл 6



Байнгын хорооны тогтоол 19



Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж даатгалын нөхөн төлбөр олгох 6 хувийн босго үзүүлэлтийг өөрчлөн, уян хатан тогтоох, улмаар Үндэсний статистикийн хорооноос гаргасан малын хорогдлын дүнд үндэслэн даатгалын нөхөн төлбөрийг хэсэгчлэн урьдчилан олгох хоёр томоохон зохицуулалтыг хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.

Түүнчлэн иргэний гаргасан цахим өргөдөлд 100 мянган хүн нэгдэж, гарын үсэг зурснаар Утааны Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах ажлыг манай байнгын хороо ахалж ажиллалаа. Дөрвөн удаагийн хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 194 иргэн, төрийн байгууллагын 93 албан тушаалтан оролцов. Үр дүнд нь утааны эсрэг хэрэгжүүлэх 13 арга хэмжээ бүхий байнгын хорооны тогтоолыг УИХ-аар батлуулж, Засгийн газарт чиглэл болгон өгөв.

Мөн түүнчлэн, үржлийн адууны импортыг 10 жилээр хориглосон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан батлуулснаар адууны удмын сангийн генетик нөөцөд ороод буй нөлөөллийг бууруулах, байгаль, цаг ууртаа дассан, хурдтай жинхэнэ монгол үүлдрийн адууг бий болгох боломжийг нээж өгсөн юм.



УИХ-ын гишүүн О.Амгаланбаатарын өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлээ. Малын дайсан чоныг агнахад өндөр төлбөр, тусгай зөвшөөрөл авдгаас улбаалж чоно агнах байдал буурснаар тоо, толгой нь өсөн нэмэгдэж малчдад учруулдаг хор, хөнөөл өндрөө авч буй. Тиймээс чоно агнах төлбөр, үйл явцыг хөнгөвчлөн зохицуулалтыг тусгасан нь нүдээ олж, УИХ өнгөрөгч тавдугаар сард эцэслэн батлав.

Монгол Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж бүр хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй байх бодлогын хүрээнд хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуй, даатгалын чиглэлээрх хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулсан хуулийн төслүүдийг ирэх намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.





МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

126 ГИШҮҮНТЭЙ
АНХНЫ ПАРЛАМЕНТЫН
1 ЖИЛ

2024 оны намар,
2025 оны хаврын
чуулганаар батлагдсан
гол хуулиуд болон
парламентын
онцлох ажил



З.МЭНДСАЙХАН

УИХ-ын гишүүн

Монгол Улсын 3.5 сая иргэний эрүүл мэндтэй шууд хамааралтай хүнс, хүнсний бүтээгдэхүүн, эм, эмийн зохистой тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал тавьж, шаардлагатай зохицуулалтыг хуульд тусгах үүргийг хүлээж Хүнс, эмийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. Бид хүнсний аюулгүй байдлаа, эм, эмийн бүтээгдэхүүнээ хянадаг бодлогын тогтолцоо буюу агентлаг байгуулах шаардлагатай гэж үзэж “Хүнс, хөдөө аж ахуйн яам”-ны дэргэд байгуулахаар урьдчилсан байдлаар дүгнээд байна. Тиймээс нэн тэргүүнд бие даасан хөндлөнгийн судалгааны байгууллагаар тусдаа агентлаг байх эсэхээр судалгаа гаргуулахын зэрэгцээ лавлагаа шатлалын лабораториуд зах зээлд байгаа эмүүдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар үйлдвэрлэсэн дугаар, эмийн найрлага дахь агууламж зэргийг нарийн шинжлэх ажлуудыг хийхээр төлөвлөж байна.



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН “ГУРВАН ТӨГӨЛДӨРШИЛ” БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖЛЫН ХЭСГҮҮД АЖИЛЛАЖ БАЙНА

2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдсан 126 гишүүнтэй шинэ парламентын өмнө хууль эрх зүйн орчныг шинэ цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлэх өндөр хариуцлага бий. Тийм учраас шинэ парламент хууль тогтоох үйл ажиллагаандаа баримтлах үндсэн ГУРВАН чиглэлээ тодорхойлсон юм.

- 1 Хүний эрхийг дээдэлсэн, хүн төвтэй хуулийн үзэл баримтлалд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлнэ.
- 2 Хууль тогтоомжийг тодорхой, ойлгомжтой болгож, хууль хүн бүрд ижил тэгш үйлчилдэг болгох чиглэлд анхаарна.
- 3 Нийгмийн хурдацтай хөгжлийн шаардлагад нийцүүлэн, эрх зүйн зохицуулалтыг цаг алдалгүй гаргаж ажиллана.

Энэ хүрээнд УИХ-ын даргын захирамжаар 80 орчим ажлын хэсэг байгуулагдан, ажиллаж байна.



ХҮН ТӨВТЭЙ, ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ПАРЛАМЕНТЫГ ТӨЛӨВШҮҮЛНЭ

76 гишүүнтэй өмнөх парламент 2023 оны тавдугаар сарын 21-ний өдөр Үндсэн хуулинд өөрчлөлт оруулах түүхэн шийдвэр гаргаснаар өнөөдрийн 126 гишүүнтэй анхны парламент “мэндэлж” 2024-2028 оны стратеги төлөвлөгөөгөө шинэчлэн баталлаа.

Монгол Улсын Их Хурлын бодлого, үйл ажиллагааны цөмд хүн байна. Шинээр гарах хууль бүр хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, олон талт түншлэлийг сайжруулсан, үндэсний язгуур эрх ашгийг цогцлоосон шинжийг агуулах юм. Мөн иргэн хууль санаачлах, хууль боловсруулахад оролцох, саналаа тусгах, биелэлтэд хяналт тавих, зэргээр улс орны бодлогод ард иргэдийн дуу хоолойг тусгадаг болсноор иргэдийн оролцоотой Ардчилсан парламентын мөн чанарыг бататгасан томоохон өөрчлөлт болов.

УЛСЫН ИХ ХУРАЛ 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГӨӨ

5 намын оролцоотой ажлын хэсэг нийт

5 зорилго, түүнд хүрэх

17 зорилтыг дэвшүүлсэн юм.



Х.БУЛГАНТУЯА

УИХ-ын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч

Энэхүү стратеги төлөвлөгөө нь Улсын Их Хурлын гишүүд, УИХ-ын Тамгын газрын төлөвлөгөө биш. Үүний гол зорилго нь Улсын Их Хурлаас хэлэлцэн батлагддаг хууль тогтоомжууд иргэд, олон нийтэд ээлтэй эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүний эрхийн зөрчилгүй нийгмийг цогцлоход чиглэж байгаа.



С.БЯМБАЦОГТ

УИХ-ын гишүүн

Энэ удаагийн парламент 5 намын төлөөлөл, жагсаалтаар болон тойргоос сонгогдсон 126 гишүүдтэй зэрэг олон онцлогтой. Тиймээс цаг үеийн нөхцөл байдалдаа таарсан тодорхой бодлого, зорилгыг тусгаж, өмнөх төлөвлөгөөнүүдтэй харьцуулж үнэлгээ хийсний үндсэн дээр боловсорч гарах ёстой.



Хуулийн хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй



Н.УЧРАЛ

УИХ-ын гишүүн, ЗГХЭГ-ын дарга

Ураны төсөл дээр Монголын урдаа барьдаг эрдэмтэн судлаач, орчин цагийн шилдэг хуульч, эдийн засагчидтай хамтран ажиллаж “авлига, ашиг сонирхол бүхнийг сөрж” ард нь гарсандаа сэтгэл дүүрэн байна. Нэг ёсондоо, Монголчууд Монголдоо, Монгол хүндээ үр өгөөжтэй, харилцан ашигтай, хамтран ажиллаж чаддаг, хэлэлцэн тохирч болдгийг батлан харууллаа.

Уранаа ашиглах дуусдаггүй яриаг дуусгалаа



З.МЭНДСАЙХАН

УИХ-ын гишүүн

Нөхөн сэргээлт хийхэд шаардлагатай 300 сая доллар авч Монголбанк дахь Төрийн тусгай дансанд байршуулна гэсэн танилцуулга бий. Энэ бол урт хугацааны асуудал. Техник, эдийн засгийн үндэслэлээр нөхөн сэргээлт хийх зардалд хүрэхгүй байдал үүсвэл хэн хариуцах вэ? Татаж төвлөрүүлснээрээ эрсдэлийг өөрсдөө үүрэх асуудал руу орохоос болгоомжлох хэрэгтэй.



Хуулийн хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй

УРАНЫ ТӨСӨЛ МОНГОЛД УЛСАД “ХАРААТ БУС” БАЙХ БОЛОМЖИЙГ НЭЭВ

2023 онд Монгол, Франц улсын Төрийн тэргүүнүүдийн харилцан айлчлалын үр дүнд, 21-р зууны эрчим хүчний гол эх үүсвэрээр нэрлэгдэж буй ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд ураныг олборлох хэлцэл үзэглэгдэх хаалга нээгдсэн юм. Үүнээс хойш Л.Оюун-Эрдэнийн тэргүүлж буй Засгийн газар Монгол Улсын шинэ 30 жилийн хөгжлийг тодорхойлж, сэргэлт авчрах 14 мега төсөлд ураны төслийг оруулж, шаардлагатай хууль тогтоомжийг шинэчилж, УИХ-аар хэлэлцэн батлуулсан. Үе үеийн эрх баригчдын дунд яригдсан ч маргаан дагуулсаар эцэст нь мартагддаг энэхүү төсөл олон жилийн дараа хэрэгжихээр болж 2025.01.17-ний өдөр гэрээг албан ёсоор үзэглэв. Энэхүү түүхэн үйл явдал нь Францын “Орона” группт ялалт болж, Монголд гуравдагч хөршийн хоёр дахь том хөрөнгө оруулалтаар дамжин хоёр улсаас “хараат бус” байх боломж бүрдэж буйг эрдэмтэд төдийгүй гаднын томоохон хэвлэлүүд онцолжээ.

УРАНЫ ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Зорилго: Ногоон эрчим хүч болох цөмийн эрчим хүчний үндсэн түүхий эд 68.9 мянган тонн уран үйлдвэрлэж, хүлэмжийн хийн ялгарлыг 3.9 тэрбум тонноор бууруулж, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэнэ.

Санхүүжилт: БНФУ-ын Засгийн газрын шууд хөрөнгө оруулалт

Нийт төсөв	2025 онд	2026 онд	2027 онд
1.6 тэрбум\$	95.8 сая\$	108.2 сая\$	140.2 сая\$

Үр дүн: Жилд 2500тн ураныг нийт 33 жилийн хугацаанд үйлдвэрлэх ба төслийн нийт хугацаанд улс, орон нутагт 5.2 тэрбум\$ татвар төвлөрүүлнэ.



ИМПОРТЫН ГУРИЛЫН ТАТВАРЫГ ТЭГЛЭСНИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОВ

2023 оны өвөл 2024 оны хаврын зуднаар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, хүндрэлийг даван туулах зорилгоор улаанбуудайн дээд болон 1-р зэргийн гурил, есөн нэр төрлийн мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийг гаалийн албан татвараас чөлөөлөөд байсан юм.

Ингэснээр хилээр орж ирэх гурилын хэмжээ эрс нэмэгдэж, дотоодын гурилын үйлдвэрлэл, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын үйл ажиллагааг тогтворгүй болгон, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг үнэгүйдүүлж, үүнээс улбаатай олон сөрөг нөлөөг дагуулж болзошгүй байсан тул импортын гурилын татварыг тэглэснийг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэнээр уг хуулийн төслийг УИХ-д хоёр удаа оруулж ирсний эцэст 2025 оны зургаадугаар сарын 25-ны өдөр батлагдав.



З.МЭНДСАЙХАН
УИХ-ын гишүүн

ОХУ-аас орж ирж буй импортын гурилын татварыг тэглэсэн асуудал нь баруун аймгуудын гол нэрийн бүтээгдэхүүн болох гурилын үнэ өсөөд байгаагаас үүдэлтэй. Улаанбаатар хотын үйлдвэрлэлээс гарч буй үнэ хямдхан бөгөөд Баян-Өлгий, Говь-Алтай руу тээвэрлэхэд 1 кг гурилын үнэ 1 дахин өсөж байна. Баян-Өлгий, Увс, Завханы боомтуудаар орж ирсэн гурилын импортын хэмжээ 30 орчим мянган тн. Энэ бүс нутгийнхныг хүндрэлтэй нөхцөл байдалд оруулахгүйн тулд Баруун таван аймагтаа импортын гурилын хөнгөлөлттэй нөхцөлийг Ерөнхий сайдын ахалдаг Хүнсний аюулгүй байдлын зөвлөл зохицуулаад явах боломжтой.

Монгол Улсын Ерөнхийлөгч
У.Хүрэлсүх гурил, улаанбуудай
тэргүүтэй 19 нэр төрлийн
хүнсийг дотооддоо үйлдвэрлэх
шаардлагатай хэмээн үзэж
“Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг
санаачилсан билээ

**Уул уурхайгаас эдийн засгийг
босгох гол тулгуур нь хүнс
хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн салбар байх
ёстой**

Хуулийн
хэлэлцүүлгийн
дэлгэрэнгүй





ЕРӨНХИЙЛӨГЧИЙН “ХОРИГ”-ИЙН ХҮРЭЭНД ТӨСВӨӨ ДАХИН ХЭЛЭЛЦЭЖ БАТАЛЛАА

Улсын Их Хурлын намрын чуулган ирэх оныхоо улсын төсвийг хэлэлцэн баталдаг нь хуулиар тогтоосон үүрэг юм. Гэхдээ 126 гишүүнтэй парламентын намрын чуулган өмнөх намрын чуулгануудын хэвшмэл жишгийг өөрчилж чадсан. Сүүлийн 10 жилд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлагын өсөлтийн хувь ойролцоо байгаа боловч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх зарлагын хувь нь орлогоосоо дунджаар 4 пунктээр илүү байсаар ирсэн. Улмаар алдагдлыг өр, зээлээр нөхөх замаар шийдвэрлэж, тухайн жилд авсан зээлийн заримыг өмнөх зээлээ төлөхөд, үлдсэн хэсгийг төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулсаар байсан.

МАНАЙ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР

2024 онд
35,2
их наяд төгрөг

2025 оны төсвийн
төсөлд энэ өр даруй
5,0
их наядаар нэмэгдсэн

2010 оноос хойш жил бүр
дунджаар
2,5
их наяд төгрөгөөр нэмэгдсэн

2025 ОНЫ ТӨСВИЙГ ДАХИН ХЭЛЭЛЦСЭНЭЭР

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн
орлого, тусламжийн дүн

33.5

их наяд төгрөг буюу дотоодын
нийт бүтээгдэхүүний

35.2

хувьд хүрсэн

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн
тэнцэл алдагдалгүй болж,
суурь тэнцэл дотоодын нийт
бүтээгдэхүүний

3.3

хувийн ашигтай байх төсвийг
баталсан.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны улсын төсөвт бүхэлд нь тавьсан хориг нь төсвийг эргэн харах нөхцөл бүрдүүлсний зэрэгцээ төсөв хэлэлцэх дэгийг цаашид сайжруулах шаардлагатай байгааг мөн харууллаа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2025 оны төсвийг хэлэлцэх дэгийн тухай нэг удаагийн хуулийг хэлэлцэн баталж, улсын төсвийг өргөн мэдүүлэх, хэлэлцэх, батлах хугацааг тусгай дэгээр зохицуулсан юм.

Хуулийн
хэлэлцүүлгийн
дэлгэрэнгүй





ЗЭЭЛДЭГЧИЙН “ХАР ЖАГСААЛТ” ГЭХ САНХҮҮГИЙН ЯЛ ХАЛАГДЛАА

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 13 банк, 400 гаруй банк бус санхүүгийн байгууллага болон төр, хувийн хэвшлийн байгууллагууд Зээлийн мэдээллийн санд иргэд, аж ахуйн нэгжүүдийн зээлийн мэдээллийг тогтмол нийлүүлдэг. Тус мэдээллийн санд 1.6 сая иргэн, 17 мянган аж ахуйн нэгжийн 4.7 сая орчим зээлийн мэдээлэл хадгалагдаж байна. Хуулийн төсөл батлагдсанаар “хар жагсаалт” гэх санхүүгийн ялд өртөөд байсан 200 мянган иргэдийн зээлийн муу түүх хүчингүй болж, онооны системд шилжих юм. Гагцхүү Хөгжлийн банк, Засгийн газрын тусгай сангаас зээл авчхаад төлөхгүй бол уян хатан тогтолцоо үйлчлэхгүй.



Хуулийн
хэлэлцүүлгийн
дэлгэрэнгүй

Учир нь энэ бол татвар төлөгчдийн мөнгө тул илүү хариуцлагатай, сахилга баттай байх учиртай.

70 мянга гаруй иргэн, ААН-ийг банкны “Хар жагсаалт”-аас гаргах Монголбанкны Ерөнхийлөгчийн захирамж 2025 оны 09 дугаар сарын 1-ний өдөр гарснаар уг хууль амьдрал дээр хэрэгжиж эхэлснийг албажууллаа.



Э.БАТШУГАР
УИХ-ын гишүүн

Манай улсад зээлдэгчийн зээлжих чадварт үнэлгээ хийх онооны аргалчлалыг эрх бүхий байгууллагаар батлуулах зохицуулалт байхгүй байсаар өнөөдрийг хүрсэн. Харин зээлдэгчийн зээлжих чадварт зэрэглэл тогтоох асуудлыг эрх бүхий байгууллагаас баталдаг болсноор үнэлгээнд суурилсан банк, санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ГАРАХ ЗЭРЭГ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Зээлдэгчийн “хар жагсаалт” гэх санхүүгийн ялыг арилгана;
- Зээлийн хүү, зээлдэгчид тавигдах барьцаа хөрөнгийн шаардлага буурна;
- Санхүүгийн үйлчилгээний хамгийн таатай нөхцөлийг зөвхөн том аж ахуйн нэгж, барьцаа хөрөнгөтэй зээлдэгч хүртдэг тогтолцоог өөрчилж, зээлдэгчийн онооны мэдээлэлд тулгуурлаж зөвхөн барьцаа хөрөнгө шаардахгүйгээр уян хатан нөхцөлтэй зээлийг санхүүгийн сахилга баттай иргэдэд олгох нөхцөл бүрдэнэ;
- Онооны систем нэвтэрснээр зээлийн эрсдэлийг үнэлэх боломж нэмэгдэж, зээлийн хүртээмж илүү оновчтой болно;
- Банк, санхүүгийн салбарын үйлчилгээний хүртээмж сайжирч, салбарын өрсөлдөөнийг нэмэгдүүлж иргэд банкны шаардлагаар бус өөрийн хүссэн банкныг сонгон үйлчлүүлдэг болно;
- Банк, санхүүгийн салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд зэрэг нөлөөлөхтэй;



Хууль тогтоомжийн тухай хууль

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь тавигдана

УИХ-ын чуулганы 2025 оны хаврын чуулганаар хүн төвтэй, цаг үеийн шаардлагад нийцсэн, иж бүрэн зохицуулалттай, ойлгомжтой хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Ажлын хэсгүүдийн санал дүгнэлт, боловсруулсан хуулийн төслүүдийг хэлэлцэж байна. Тухайлбал, хүн төвтэй хууль зүйн бодлогын суурь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тавигдах ёстой. Хууль бүтээх сэтгэлгээг өөрчлөхгүйгээр эрх зүйн хөгжилд хүрэх боломжгүй. Хуулийн төвд хүн орших учиртай. Хууль хэнийг ч үл ялгаж, эрх тэгш хэрэгжиж, хууль дээдлэх ёс бүрэн тогтох ёстой.

“Өнөөгийн Монгол Улсын нийгмийн харилцааг 1992 оны Үндсэн хуулиар тунхагласан зарчим, үзэл санаа, түүнд нийцүүлэн боловсруулсан хууль тогтоомжоор зохицуулж байна.



Д.АМАРБАЯСГАЛАН

УИХ-ын дарга

Өнөөдөр хууль ба журмын зохист харьцаа алдагдсаны улмаас хууль биш, харин журам ноёлж байна. Албан тушаалтны үзэмжээр хандах, авлига, хүнд суртал газар авах хөрс болж байгаа журмуудыг үндсээр нь устгаж, хууль дээдлэх зарчмыг бодит утгаар хэрэгжүүлэх цаг ирсэн.



З.МЭНДСАЙХАН

Ажлын хэсгийн гишүүн

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар зах зээлийн шударга өрсөлдөөн, эдийн засгийн тэлэлтийг дэмжих, эрчим хүчний салбарыг либералчлах, бүсчилсэн хөгжил, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, аж үйлдвэрийн парк байгуулах боломжийг нэмэгдүүлсэн эрхзүйн орчныг дэмжих хуулийн төслүүдэд анхаарал хандуулан ажиллана.





ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫГ ХУУЛЬЧИЛСНААР ТОГЛОХ ХҮМҮҮСИЙН ТОО 65 ХУВИАР БУУРНА

Цахим мөрийтэй тоглоомын хамгийн том хор уршиг нь “донтолт”. Үүнээс үүдэн залуус амьдралаараа бооцоо тавьж, нийгэмд хөл алдаж байна. Амьдралаа алдаж, өр зээлд орсон олон монгол хүн, олон өрх гэрийн зовлон бидний өмнө байгаа нь нууц биш!

Монгол Улсын хувьд цахим болон цахим бус хэлбэрээр хууль бусаар мөрийтэй болон бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах замаар мөнгө угаах, бусдыг залилах, татвар төлөхөөс зайлсхийх эдийн засгийн гэмт хэрэгт өнөөдрийг хүртэл нарийвчилсан зохицуулалтгүй явж ирсэн. Тэгвэл улсын эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулж, эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй үйлдлийг таслан зогсоох зорилгоор Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-аар хэлэлцэн баталлаа.

ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ГАРАХ ЗЭРЭГ ҮР ДҮН

Энэ чиглэлийн платформууд хориглогдож, зар сурталчилгаа, агентуудын үйл ажиллагаа бүр мөсөн зогсоно;

Цахим мөрийтэй тоглоом тоглох хүмүүсийн тоо 65 хувиар буурна;

Гадагш хяналтгүй гарч буй 500 сая ам.долларт зохих байгууллагаас хяналт тавих боломж бүрдэнэ;

Хүүхэд, залуучууд мөрийт болон бооцоот тоглоом тоглож сэтгэл зүйн хувьд донтох, эрүүл мэнд, амь насанд учрах эрсдэлээс сэргийлнэ;

Мөрийтэй тоглоомыг сурталчлах нь хэвийн мэт хэвшсэн ойлголтыг өөрчилж, хүүхэд, залуучуудыг бооцоот тоглоом, мөрийтэй тоглоомд уриалан дуудаж буй хууль бус сурталчилгаануудыг таслан зогсооно;

ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРГИЙН
ХОХИРОГЧДЫН 50 ХУВЬ НЬ
30-39 НАСНЫХАН

ЦАХИМ МӨРИЙТЭЙ ТОГЛООМЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ,
БУСАД ИХ ХЭМЖЭЭНИЙ
ХОХИРОЛ УЧРУУЛВАЛ

2-8 ЖИЛИЙН
ХОРИХ ЯЛТАЙ



Н.УЧРАЛ
УИХ-ын гишүүн

Мөн сүүлийн 3 жилийн хугацаанд давхардсан тоогоор хууль бус мөрийтэй тоглоомын 350-450 орчим сайт үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд цахим болон бооцоот мөрийтэй тоглоом эрхэлдэг гадаадын хуулийн этгээдийн үйл ажиллагаа түгээмэл байгаа нь тулгамдсан асуудал болоод буй.



Хуулийн
хэлэлцүүлгийн
дэлгэрэнгүй



ЗАМЫН-ҮҮД, ЭРЭЭНИЙ
БООМТ ТӨМӨР ЗАМААР
ХОЛБОГДСОНООС ХОЙШ

70 орчим жилийн

ДАРАА ӨМНӨД ХӨРШТЭЙГӨӨ
ТӨМӨР ЗАМААР ХОЛБОГДОХ

ХОЁР ДАХЬ

БООМТЫН ҮҮД, ХААЛГА
НЭЭГДЛЭЭ.

21 ЖИЛИЙН ГАЦААНААС ГАРЧ “ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД” ХИЛ ХОЛБОЛТЫН ТӨМӨР ЗАМЫН АЖИЛ УРАГШИЛЛАА

Улсын Их Хурал мега төслүүд хэрэгжих эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж буй. Тухайлбал “Гашуунсухайт-Ганцмод” хил холболтын төмөр замын төсөл гацаанаас гарсан. Үр дүнд нь экспортын хүчин чадал нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэх юм.

2024.12.27

“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсан юм.

2025.02.14

“Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурж баталгаажууллаа.

2025.03.27

Гашуунсухайт-Ганцмод боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталлаа.



С.БЯМБАЦОГТ

УИХ-ын гишүүн

Монгол Улс дэлхийн хамгийн том зах зээлтэй хоёр улстай хөрш. БНХАУ бол байгалийн баялгийн маш том хэрэглэгч. Бид уул, уурхайн бүтээгдэхүүн буюу нүүрсээ урд хөрштөө борлуулж эдийн засгаа авч явдаг. Замын-Үүд боомтоос хойш 70 жилийн дараа Гашуунсухайт-Ганц боомтын төмөр замын холболтыг хийснээр эдийн засгаа 2 дахин тэлэх боломжийг нээж байна.

Хуулийн
хэлэлцүүлгийн
дэлгэрэнгүй





МОНГОЛ УЛСЫН
БАЙНГЫН АЖИЛЛАГААТАЙ ПАРЛАМЕНТЫН ТҮҮХЭН ДЭХ
ЕС ДЭХ УЛСЫН ИХ ХУРАЛ

